



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМ ДАХЬ ЗАМ
шалгаруулалтын ХАРИУЦАГЧ
нэр:

Тендер
шалгаруулалтын ЗТХЯ/20240101085
дугаар:

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
1. Тендерийн цар хүрээ.....	7
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	7
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	7
4. Худалдан авах ажиллагааны цахим систем.....	7
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.....	7
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	7
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	8
B. АГУУЛГА	8
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	8
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	9
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	9
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	9
C. ТЕНДЕР БЭЛТГЭХ	9
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	9
13. Тендерийн иж бүрдэл.....	10
14. Тендерийн жишиг маягтууд	10
15. Хувилбарт санал	10
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг.....	11
17. Чадавхын болон туршлагын шаардлага	11
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	11
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	12
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	12
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	12
22. Тендерийн валют.....	13
23. Тендер хүчинтэй байх хугацаа	13
24. Тендерийн баталгаа.....	13
D. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ.....	14
25. Тендер баталгаажуулах, илгээх	14
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	14
E. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	14

27.	Тендерийн талаар тодруулга авах	14
-----	---------------------------------------	----

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

28.	Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	14
29.	Тендерийг үнэлэх	15
30.	Арифметик алдааг залруулах.....	15
31.	Давуу эрх олгох	15
32.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	15
33.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	15
34.	Тендерийг эрэмбэлэх.....	15
35.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	15
E.	МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	16
36.	Мэдэгдэл хүргүүлэх	16
37.	Гүйцэтгэлийн баталгаа.....	16
38.	Урьдчилгаа төлбөр	16
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	16

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьялалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага

баримт

хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг

эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх 25.1. Тендерийг хуулийн баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлттээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлттээр оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга

хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- | | |
|---|--|
| 36. Шийдвэр хүргүүлэх | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| 37. Гүйцэтгэлийн баталгаа | 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана. |
| 38. Урьдчилгаа төлбөр | 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, too хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна. |
| 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. |

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ		А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1		Захиалагч: Зам, тээврийн хөгжлийн яам
ТШЗ 1.1		Тендер шалгаруулалтын нэр: Булган аймгийн Дашичилэн сум дахь зам хариуцагч
ТШЗ 1.1		Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ЗТХЯ/20240101085
ТШЗ 1.2		Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “багцгүй”.
ТШЗ 1.3		Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1		Санхүүжилтийн эх үүсвэр нь: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2024 оны төлөвлөгөө”.
ТШЗ 2.1		Нийт төсөвт өртөг: 784,723,000.0
Б.АГУУЛГА		
ТШЗ 9.1		Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Авто замын бодлого, зохицуулалтын газар Хаяг: Зам, тээврийн хөгжлийн яам, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын 13-р байр. Утасны дугаар: 263207 Цахим шуудангийн хаяг: info@mrtd.gov.mn
ТШЗ 10.1		Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ		
ТШЗ 12.1		Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1		Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”.
ТШЗ 16.1.2		Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардахгүй”
ТШЗ 18.1		Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил /2021, 2022, 2023 он/ 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн зам хариуцагчийн батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна. Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 20 хувиас багагүй

	байна.																																																				
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 3 жил /2021, 2022, 2023 он/</p> <p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p>																																																				
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”.</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Байвал зохих хамгийн бага</th> <th>Ажилласан туршлага</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий инженер</td> <td>1</td> <td>5</td> <td>Авто замын инженер</td> </tr> <tr> <td>2</td> <td>Талбайн инженер</td> <td>1</td> <td>3</td> <td>Авто замын инженер</td> </tr> <tr> <td>3</td> <td>Материалын инженер</td> <td>1</td> <td>3</td> <td>Авто зам болон барилгын инженер</td> </tr> <tr> <td>4</td> <td>ХАБЭА-н ажилтан</td> <td>1</td> <td>1</td> <td>ХАБЭА-ын чиглэлээр мэргэшсэн байна.</td> </tr> <tr> <td>5</td> <td>Мэргэжилтэй ажилтан, замчин, жолооч, механизмчин.</td> <td>5</td> <td>-</td> <td>Үнэмлэх</td> </tr> <tr> <td colspan="2">Дүн</td><td>9</td><td></td><td></td></tr> </tbody> </table> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”.</p> <p>Дээрх хүснэгтүүдэд заагдсан ерөнхий инженер, талбайн инженер, ХАБЭА-н ажилтан нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх бөгөөд сүүлийн 3 сар болон түүнээс дээш хугацаанд тухайн байгууллагад ажилласан байна.</p> <p>Ерөнхий инженер, талбайн инженер, ХАБЭА-н ажилтан нарыг тухайн байгууллагын үндсэн ажилтан болохыг нотлохын тулд “E-mongolia” системээс сүүлийн 3 сар болон түүнээс дээш хугацаанд төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт авч ирүүлэх шаардлагатай.</p> <p>Гэрээгээр ажиллах бол гэрээ, диплом, цахим үнэмлэхний хуулбаруудыг тус тус ирүүлнэ.</p> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”.</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Машин механизмын нэр</th> <th rowspan="2">Байв ал зохих</th> <th colspan="2">Эзэмшлийн байдал</th> </tr> <tr> <th>Өөрийн</th> <th>Түрээсийн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Экскаватор 0.25 м3-буюу түүнээс дээш шанагатай</td> <td>1</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td>Ачигч</td> <td>2</td> <td>1</td> <td>1</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Байвал зохих хамгийн бага	Ажилласан туршлага	Мэргэжил	1	Ерөнхий инженер	1	5	Авто замын инженер	2	Талбайн инженер	1	3	Авто замын инженер	3	Материалын инженер	1	3	Авто зам болон барилгын инженер	4	ХАБЭА-н ажилтан	1	1	ХАБЭА-ын чиглэлээр мэргэшсэн байна.	5	Мэргэжилтэй ажилтан, замчин, жолооч, механизмчин.	5	-	Үнэмлэх	Дүн		9			№	Машин механизмын нэр	Байв ал зохих	Эзэмшлийн байдал		Өөрийн	Түрээсийн	1	Экскаватор 0.25 м3-буюу түүнээс дээш шанагатай	1	1		2	Ачигч	2	1	1
№	Албан тушаал	Байвал зохих хамгийн бага	Ажилласан туршлага	Мэргэжил																																																	
1	Ерөнхий инженер	1	5	Авто замын инженер																																																	
2	Талбайн инженер	1	3	Авто замын инженер																																																	
3	Материалын инженер	1	3	Авто зам болон барилгын инженер																																																	
4	ХАБЭА-н ажилтан	1	1	ХАБЭА-ын чиглэлээр мэргэшсэн байна.																																																	
5	Мэргэжилтэй ажилтан, замчин, жолооч, механизмчин.	5	-	Үнэмлэх																																																	
Дүн		9																																																			
№	Машин механизмын нэр	Байв ал зохих	Эзэмшлийн байдал																																																		
			Өөрийн	Түрээсийн																																																	
1	Экскаватор 0.25 м3-буюу түүнээс дээш шанагатай	1	1																																																		
2	Ачигч	2	1	1																																																	

	3	Автогрейдер	2	1	1	
	4	Индүү/ 4тн/	1	1		
	5	Доргиурт индүү /10 тн-с дээш/	1		1	
	6	Замын үзлэгийн машин	1	1		
	7	Өөрөө буулгагч авто машин /даац 5-10 тн/	2	2		
	8	Усны машин	1		1	
	9	Арчлалт, засварын тоноглол бүхий машин, механизм	2	2		
	10	Суурин болон нүүдлийн асфальтбетон завод	1	1		
	11	Зам засварын тоног төхөөрөмжүүд /зүсэгч хөрөө, нягтуулагч тус бүр/	1	1		
	ДҮН		15	11	4	
ТШЗ 19.2	<p>Дээрх хүснэгтэд байгаа гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд өөрийн эзэмшлийн байх тоо нь шалгуур үзүүлэлтийн доод хязгаар болно. Жич: Асфальтбетон заводын хувьд тухайн аймаг, орон нутагт ажиллаж буй заводоос худалдан авахаар гэрээ байгуулсан байж болно.</p> <p>Гэрчилгээний хуулбар, фото зураг, хүчин чадлыг харуулсан нотлох баримтгүй бол өөрийн эзэмшлийнх гэж тооцохгүй.</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”.</p> <p>Ижил төстэй гэрээний туршлага: Сүүлийн 3 жил /2021, 2022, 2023 он/ байх бөгөөд уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна.</p> <p>Ижил төстэй ажилд дараах ажлууд хамаарна. Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын өвлийн арчлалтын ажил - Хатуу хучилттай авто замын хучилтын нөхөөсний ажил - Хатуу хучилттай авто замын ан цав хагарлыг гагнах ажил - Авто замын гүүр, хиймэл байгууламжийн засварын ажил <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”.</p> <p><i>-Ажил гүйцэтгэх гэрээ, гүйцэтгэлийн мэдээ ирүүлэх</i></p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардахгүй”</p>					
	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> Хариуцан ажиллах авто зам, замын байгууламжид үзлэг хийж засвар арчлалтын ажлын төрөл, тоо хэмжээг тогтоож, ажил бүрээр нэгж үнэлгээ 					

	<p>гарган эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>2. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>3. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> <p>4. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>5. Тендерт оролцогч нь тендериийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, тайлж унших боломжтой байх шаардлагатай.</p> <p>6. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ хавсаргах</p> <p>7. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл</p> <p>8. Тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тодорхойлолт ирүүлэх</p> <p>9. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 оноор авна.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендериийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендериийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”.</p> <p>-Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны A/101 тоот тушаалын 2.8.2.5.2 Бүх төрлийн зам, гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил,</p> <p>-Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны A/177 тоот тушаалын 5.2.3.4 Авто зам, замын байгууламжийг арчлах</p>
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй”
ТШЗ 24.1	Тендериин баталгааны дүн: Тендериийн баталгааны дүнг төсөөт өртгийн 0.5 хувиар тооцож ирүүлнэ.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Хуульд заасны дагуу
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр.</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>

ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр. Цаг: 10 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын 13-р байр, 4 давхар, 401 тоот.
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “ <i>Тийм</i> ” <i>Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</i>
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “ <i>Тийм</i> ” <i>Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : гэрээний үнийн дүнгийн [30] хувь</i> <i>Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлнэ.</i>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тендерт оролцогч нь авто замын засвар, арчлалтын ажил гүйцэтгэх эрх бүхий /Тусгай зөвшөөрөлтэй/ байгууллага байна.

Булган аймгийн Дашичилэн сум дахь зам хариуцагч нь “Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг хариуцан ажиллах гэрээ”, “Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2024 онд хийгдэх арчлалт, засварын ажлын гэрээ”-г тус бүр байгуулж гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

Улсын чанартай авто зам, замын байгууламж хариуцагч нь авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг тухайн онд төлөвлөгдсөн хөрөнгөнд багтаан чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, ажлын гүйцэтгэлээр санхүүжинэ.

Тендерт оролцогч нь тухайн хариуцах авто зам, замын байгууламжийн дагууд байнгын болон шуурхай хэсэг байгуулах объект, тоног төхөөрөмж, мэргэжилтэй ажилчдын нөөц чадвартай байх ба тухайн аймаг суман дээр шуурхай ажлын хэсгийг зохион байгуулж ажиллах төлөвлөгөө ирүүлэх шаардлагатай.


Зам хариуцагч нь авто зам, замын байгууламжийг жилийн турш тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрэн хангаж, авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг бууруулахгүйгээр байнгын бэлэн байдалд байлгана.

Авто зам, замын байгууламжийн хариуцагч нь Монгол улсын “Авто замын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасан “зам хариуцагч”-ийн үүргийг хүлээж ажиллана.

Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг холбогдох техникийн шаардлага, норм дүрэм стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Тендерт оролцогчид тухайн чиглэлд хариуцах авто зам, замын байгууламжийг газар дээр нь очиж үзлэг шалгалт хийсэн байна. Хариуцан ажиллах авто замын схем зураглалыг хавсаргав. Хавсралт №01

**БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМ ДАХЬ
ЗАМ ХАРИУЦАГЧИЙН ХАРИУЦАН АЖИЛЛАХ
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН
СХЕМ ЗУРАГЛАЛ**



Замын дугаар	Замын чиглэлийн нэр	Хариуцах замын урт /км/	Хариуцах замын эхлэл төгсгөл	Хүчинтэй төрөл	Урт /км/	Хариуцах замын эхлэл төгсгөл
A27	Лүн Дашинчилэн	172.76	0 - 172.76	Асфальтбетон	76.66	Лүнгийн гүүрний цаана Хангайн давааны замын уулзвараас - 172.76 км-т
				Асфальтбетон	96.1	
A0901	Дашинчилэн-Булган	60	0 - 60	Ердийн хөрс	60	Харбухын гүүрнээс Бүрэгхангай сүм өнгөрөөд 60-км-т
НИЙТ		232.76			232.76	

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: “Ашиглахгүй”

1. *Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “Ашиглахгүй”*
2. *Байгаль орчинд нөлөөлөх байдал: “Ашиглахгүй”*
3. *Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “Ашиглахгүй”*

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1. Тендер илгээх

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодогтүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо] өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

БАТЛАВ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧ:

“....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... оны ... дугаар сарын ...

..... оны ... дугаар сарын ...

УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИД 2024 ОНД АРЧЛАЛТ, ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

..... оны ... дугаар сарын ...

Дугаар

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид “захиалагч” гэх/ нөгөө талаас “....” ХХК /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл.

1.1.Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний /цаашид “гэрээ” гэх/ зорилго оршино.

1.2.Ажил гүйцэтгэгч нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/341 дүгээр тушаалаар батлагдсан хөрөнгөнд багтаан өөрийн хариуцдаг улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг гүйцэтгэн авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн ханган үндсэн үүргийг хүлээнэ.

1.3.Энэхүү гэрээ нь авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төсөвт өртөг, чанар, хүчин чадлыг эцэслэн тохирох үндэслэл болно.

1.4.Гэрээгээр хариуцсан улсын чанартай авто зам, замын байгууламжид арчлалт, засварын ажлыг дараах хүснэгтэд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

№	Замын код	Замын чиглэл	Хучилтын төрөл	Замын урт /км/	2024 оны төлөвлөгөө /төгрөг/
1					
		Дүн			

1.5.Гэрээний дүн /...../ төгрөг болно.

1.6.Энэхүү гэрээ нь 2024 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хүчинтэй байна.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1.Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд тавих хяналтыг захиалагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч /цаашид “зөвлөх” гэх/ гүйцэтгэнэ.

2.2.Тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжид хийгдэх арчлалт, засварын ажлын төрөл, тоо хэмжээг захиалагч, захиалагчийн төлөөлөгч, гүйцэтгэгчийн хамт үзэж тодорхойлон график төлөвлөгөөг батална.

2.3.Ажлын гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтууд баталгаажуулах бөгөөд гүйцэтгэлийг хянаж шалгах явцад БНБД, стандарт, техникийн шаардлагыг зөрчиж хийсэн ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэхгүй бөгөөд зөрчлийг арилгасны дараа ажлын гүйцэтгэлийг дахин хянаж, баталгаажуулан санхүүжүүлэх хугацааг шинээр тооцох ба үүнээс шалтгаалан гарсан хохирлыг захиалагч хариуцахгүй.

2.4.Авто зам, замын байгууламжид хийгдсэн арчлалт, засварын ажлыг хянаж шалгахдаа “Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын зохион байгуулалтын техникийн дүрэм” /ЗЗБНБД 41-011-2016/, “Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм” /ЗЗБНБД 41-010-2016/, “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага”, “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНБД 81-013-2019, төсвийн норм үнэлгээнүүдийг үндэслэл болгоно.

2.5.Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын явц, чанар аюулгүй байдал, шуурхай ажлын хэсэг, гүүр хамгаалагч, төлбөр авах цэгийн үйл ажиллагааг захиалагч, зөвлөх газар дээр нь үзэж шалгана. Захиалагчийн зүгээс баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ажлын явц, чанар, бэлэн байдалд шалгалт хийж, гарсан дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээг авна.

2.6.Тухайн замд хийж гүйцэтгэсэн авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажил нь аюулт үзэгдэл, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас эвдэрч, гэмтсэн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол зохих актыг үндэслэн гарсан бодит зардлыг гүйцэтгэгчид төлнө.

2.7.Урьдчилгаа санхүүжилт нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй бөгөөд санхүүжилтийг авто замын арчлалт, засварын ажлын голлох түүхий эд болох битум, цемент, арматур, шатахуун, сэлбэг хэрэгсэл, цас, мөс хайлзуулах бодис худалдан авахад зориулан олгож болно. Урьдчилгаа төлбөрийг энэхүү зориулалтаас өөрөөр ашиглахыг хориглоно.

2.8.Урьдчилгаа санхүүжилт нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх санхүүжилтийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэн төлөгдөх ба олгосон урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж, хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлээс 10 дугаар сарын 01-ний дотор суутгаж дууссан байна.

2.9.Хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтооолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу санхүүжүүлнэ.

2.10.Захиалагч шуурхай ажлын хэсэг, гүүр хамгаалагч, төлбөр авах цэгийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэр, дүрэм, журмыг боловсронгуй болгон, заавар зөвлөмж өгч ажиллана.

2.11.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхул зохих ёсоор биелүүлээгүй нь хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартаар батлагдсан тохиолдолд Захиалагч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг.

3.1. Гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын төрөл, тоо хэмжээ, аргачлалыг замын чиглэл тус бүрээр захиалагч, зөвлөхтэй хамт газар дээр нь үзэж тогтоосон байна.

3.2.Тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжид төлөвлөгдсөн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын нарийвчилсан график төлөвлөгөө, аргачлалыг хийж, тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор захиалагчаар батлуулна.

3.3.Гүйцэтгэгч нь авто замын арчлалт, засварын ажлыг аюулт үзэгдэл, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас батлагдсан графикт хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчаас зөвшөөрөл авч график, төлөвлөгөөг шинэчлэн батлуулж заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

3.4.Баталгаажсан ажлын тодорхойлолтыг үндэслэн төсөв бodoх нормын дагуу тухайн байгууллагын мэргэжлийн төсөвчин ажлын төсвийг гарган захиалагч, захиалагчийн төлөөлөгчөөр хянуулж батлуулна.

3.5.Арчлалт, засварын ажилд ашиглагдах асфальт, битум, цемент, элс, хайрга, бетон гэх мэт материалын орц, хөвөө болон далан суурийн материалыг ажил эхлэхээс өмнө итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэн дүгнэлт гаргуулах бөгөөд гарсан үр дүнг 7 хоногийн дотор захиалагчид хүргүүлж, зөвшөөрөл авсан байна.

3.6.Гүйцэтгэгч нь авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг холбогдох норм, дүрэм, стандарт, журмыг баримтлан, гэрээнд болон график төлөвлөгөөнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан техникийн шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, авто зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдлыг ханган ажиллана.

3.7.Гүйцэтгэгч гэрээнд заасан үүрэг, хариуцлагыг ханган ажиллахын тулд арчлалт, засварын явцад дотоодын хяналт, шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэнэ. Хяналт шалгалтыг удирдамжийн дагуу мэдлэг, ур чадвартай, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэшсэн эрх бүхий хүнээр гүйцэтгүүлнэ.

3.8.Шуурхай ажлын хэсгийг тогтоосон цэгт, заасан хугацаанд, хүн хүч, машин механизмын хамт ажиллуулж, авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын мэдээг нэгтгэн тогтмол захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

3.9.Хариуцаж буй гүүрийн хамгаалагч-арчлагчийг мэргэжлийн удирдлагаар ханган шаардлагатай заавар, зөвлөгөө өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж “Гүүр хамгаалагч-арчлагчийн ажиллах заавар”-ыг мөрдлөг болгон үр дүнтэй ажиллуулна.

3.10.Арчлалт, засварын ажлын үе шат бүрийг огноо бичиж байршил заасан самбар, тэмдэг болон тухайн байдал, орчныг харуулсан фото зураг, зөвлөхийн хяналтын инженерийн дүгнэлт, бусад шаардлагатай баримтаар баталгаажуулан гүйцэтгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бичиж захиалагчид ирүүлнэ.

3.11.Гүйцэтгэлийг тусгай дэвтэр нээн зөвлөхийн хяналтын инженерт хүлээлгэн өгөх ба гүйцэтгэл ирүүлсэн хугацааг тухайн дэвтэр дээр бичигдсэн огноог үндэслэн тооцох бөгөөд хийсэн ажлын гүйцэтгэлийг заасан хугацаанд ирүүлээгүй, буруу

зөрүү бичсэн, баталгаажуулалтыг дутуу бүрдүүлснээс шалтгаалан санхүүжүүлэх хугацаа алдагдсанаас гарах хохирлыг гүйцэтгэгч бүрэн хүлээнэ.

3.12.Гүйцэтгэгч нь гэрээт ажлын 10 хүртэлх хувьд туслан гүйцэтгэгч ажиллуулж болох бөгөөд хэтэрсэн тохиолдолд захиалагчаас заавал зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүйгээр ажиллуулсан тохиолдолд туслан гүйцэтгэгч, гэрээт ажилтны хийж гүйцэтгэсэн ажлын 10 хувиар торгууль ногдуулна. Туслан гүйцэтгэгч, гэрээт ажилтан нь Гүйцэтгэгчийн өмнө хариуцлага хүлээнэ.

3.13.Гүйцэтгэгч нь өөрийн хариуцдаг улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлыг техникийн шаардлагын дагуу хийж гүйцэтгээгүй, түүнчлэн авто зам, замын байгууламжид гарсан эвдрэлийг засварлаагүйгээс гарах хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

3.14.Авто зам, замын байгууламжид хийгдсэн арчлалт, засварын ажлын элементийн мэдээг холбогдох маягт зааврын дагуу 7 дугаар сарын 01, 12 дугаар сарын 10-ны дотор гаргаж зөвлөхөд албан тоотоор ирүүлсэн байна. Элементийн мэдээг хугацаанд нь ирүүлээгүй бол удирдах дээд байгууллагын үүрэг даалгаврыг биелүүлээгүйд тооцно.

3.15.Авто зам, замын байгууламжид хийсэн засварын ажлын баталгаа нэг жил байх бөгөөд энэ хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас болж эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлан хүлээлгэж өгнө.

3.16.Гүйцэтгэгч нь замын засварын ажил гүйцэтгэхдээ зайлшгүй зам хааж гүйцэтгэх тохиолдолд холбогдох журмыг баримтлан автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнд сaad учруулахгүйгээр түр замыг техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэсний дараа засварын ажлыг хийнэ. Түр замд техникийн шаардлагын дагуу арчлалт, засварын ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд түр замд тэмдэг, тэмдэглэгээ, мэдээлэх самбарыг тавихдаа холбогдох байгууллагаас шаардлагатай зөвшөөрлийг авч байршуулсан байна. Захиалагч түр замын ашиглалтаас үүдэлтэй ямар нэгэн нэхэмжлэлийг хариуцахгүй.

3.17.Зам хариуцагч нь батлагдсан график, төлөвлөгөөний дагуу замын арчлалт, засварын ажлыг цаг тухайд нь чанартай сайн гүйцэтгэх бөгөөд замын барилга, засварын ажлын тендерт орох тохиолдолд захиалагчаас тухай бүрд нь зөвшөөрөл авна. Тендерт шалгаран ажил гүйцэтгэх бол арчлалт, засварын ажлыг тэргүүн ээлжинд, хугацаанд нь чанартай хийх үүрэгтэй.

3.18.Хариуцан ажиллаж буй авто зам, замын байгууламжаа болзошгүй байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, зам хэрэглэгчдийг тав тухтай зорчих нөхцөлийг хангахад онцгой анхаарч ажиллах бөгөөд авто зам, замын байгууламжийн бэлэн болон ашиглалтын байдалд тогтмол үнэлэлт дүгнэлт өгч захиалагчийг мэдээллээр хангах үүрэгтэй.

3.19.Хянаж баталгаажуулахаар ирүүлсэн ажлын тоо хэмжээ, үнэн бодит бичигдсэн эсэхийг тухайн гүйцэтгэгч компани захиалагч, зөвлөхийн өмнө бүрэн хариуцна.

3.20.Авто замын арчлалт, засварын ажлын хянацсан гүйцэтгэл, авсан урьдчилгаа, санхүүжилтийн тооцоог улирал тутамд захиалагчтай нийлж актаар баталгаажуулна.

3.21.Жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын зөвлөмж, дүгнэлт, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэл, хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг 3 дугаар сарын 15-ны дотор захиалагчид ирүүлнэ.

Дөрөв. Захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага

4.1. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг гүйцэтгэгчийг байлцуулан гэрээг дүгнэнэ.

4.2. Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал нь хариуцна.

4.3. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу ажилдаа алдаа, дутагдал, зөрчил, доголдол гаргасан бол захиалагч мэдэгдэл өгч, тодорхой заасан хугацаанд гаргасан алдаа, дутагдал, зөрчил, доголдлыг арилгаж үүргээ биелүүлэхийг шаардана.

4.4. Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.25 хувиар буруутай талдаа алданги ногдуулна. Алданги ногдуулснаар тухайн ажлыг гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 30 хувиас хэтэрч болохгүй.

4.5. Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын чанар байдлыг шалгах хяналт, шалгалтын ажлын явцад төлөвлөгөөт ажлаа гүйцэтгээгүй болон чанаргүй гүйцэтгэсэн, авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангаж чадаагүй зам хариуцагч, холбогдох албан тушаалтан зохих хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

4.6. Гаргасан алдаа, зөрчил, доголдлыг заасан хугацаанд арилгаж үүргээ биелүүлээгүй, ажил гүйцэтгэхээс татгалзсан, дампуурсан, эсхүл татан буугдах талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол захиалагч нь гүйцэтгэгчид гэрээ цуцлах талаар мэдэгдэл өгснөөс 14 хоногийн дараа гэрээ цуцлагдана.

4.7. Гэрээг цуцлах захиалагчийн шийдвэр нь гэрээний дагуу хүлээсэн захиалагчийн бусад эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Энэхүү гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал маргаан, зөрөлдөөнийг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.2. Маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж Зам, тээврийн хөгжлийн яам, Гүйцэтгэгч тус бүр хадгална.

6.3. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр гэж тооцогдох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

6.4. Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг дараах хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэх нь талуудын үүрэг ба ийнхүү мэдээлээгүйгээс мэдэгдэл, албан бичиг хүрээгүйн хариуцлагыг тэдгээрийн хүргүүлсэн тал хариуцахгүй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

АВТО ЗАМЫН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАМЫН
АШИГЛАЛТ, ЗАСВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

“....” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ САНХҮҮЧ

ЗАМЫН АШИГЛАЛТ ЗАСВАРЫН ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

ХАЯГ:

ХАЯГ:

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр.
Тендер шалгаруулалтын төрөл: Ажил
Тендер шалгаруулалтын нэр: *Булган аймгийн Дашинчилэн сум дахь зам хариуцаагч.*
Тендер шалгаруулалтын дугаар: 3ТХЯ/20240101085
Нийт төсөвт өртөг: 784,723,000.0
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

- Зам, тээврийн хөгжлийн яам нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “Үгүй”
- Тендерийг Тендерийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: “Тийм”. Тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: Зам, тээврийн хөгжлийн яам, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын 13-р байр, 401 тоот өрөө.

Цахим шуудангийн хаяг: info@mrtd.gov.mn

Утасны дугаар: 263207